

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ДОЛГОРСҮРЭНГИЙН ГЭРЭЛЭЭГИЙН
2018 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

1. Бодлогын зорилтын чиглэлээр

№	Төлөвлөсөн ажил	Хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
1	Дээд шатны байгууллагаас ирүүлсэн үүрэг даалгавар, чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах	Иргэд төрийн байгууллагаас албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг НЗДТГ-ын 2013 оны 12 дугаар сарын 10-ний өдрийн А/1086 Захирамжаар батлагдсан журмын дагуу зохион байгуулан өдөр тутам хяналт тавин ажиллаж байна.	80%

2. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

№	Хийх ажил	Хугацаа	Шалгуур үзүүлэлт буюу үр дүн	Тайлбар
1	Засаг дарга болон дүүргийн удирдлагууд иргэдтэй уулзах уулзалтыг зохион байгуулах	1 сар	2017 оны 1 дүгээр сард Засаг дарга болон дүүргийн удирдлагууд иргэд хүлээн авах уулзалтыг зохион байгуулж, уг уулзалтаар гарч буй иргэдийн гомдол, санал, хүсэлтийг тэмдэглэл хөтлөн шийдвэрлэлтэнд хяналт тавин ажиллаж байна. 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал Засаг дарга нийт 25 иргэнийг хүлээн авч уулзаж, шууд шийдвэрлэх боломжтой өргөдөл, гомдол, санал хүсэлтийг холбогдох мэргэжилтнүүдийг нь байлцуулан асуудлыг тухай бүрт нь шийдвэрлэн ажилласан. Бичгээр өгч шийдвэрлүүлэх зөвлөгөө өгсөн иргэдийн өргөдлийг хүлээн авч өргөдөл гомдлын нэгдсэн цахим программд бүртгэн хуулийн хугацаанд шийдвэрлэн иргэдэд	100%

			холбогдох хариуг өгч ажилласан.	
2	Засаг дарга болон дүүргийн удирдлагууд иргэдтэй уулзсан уулзалтын сар бүрийн тайлан мэдээг дүүргийн цахим хуудсаар мэдээлэх	1 сар	Дүүргийн удирдлагууд иргэдтэй уулзсан уулзалтын мэдээг www.bgd.mn цахим хуудсанд байршуулан иргэдэд ил тод, нээлттэй мэдээлж ажилласан.	100%
3	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн сар, улирал бүрийн тайлан мэдээг дүүргийн цахим хуудсаар мэдээлэх	1 сар	Сар бүрийн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг www.bgd.mn цахим хуудас буюу мэдээллийн самбарт байршуулан иргэдэд ил тод, нээлттэй мэдээлсэн.	100%

3. Үндсэн үзүүлэлтийн чиглэлээр

№	Төлөвлөсөн ажил	Хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
1	Иргэд төрийн байгууллагаас албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг НЗДТГ-ын 2013 оны 12 дугаар сарын 10-ний өдрийн А/1086 Захирамжаар батлагдсан журмын дагуу зохион байгуулан ажиллах	Улаанбаатар сонсож байна “Цахим өргөдөл, гомдлын нэгдсэн систем”-ийг ашиглан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шилжүүлэх, шийдвэрлүүлэх, эргэн мэдээлэх үйл ажиллагааг удирдлагын заалтын дагуу зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2017 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал нийт 72 өргөдөл, гомдол ирсэн байна. Нийт 72 өргөдлөөс шийдвэрлэсэн 41 буюу 57 %, шийдвэрлэх шатандаа 31 буюу 43 %, эзэлж байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 11 хоног 4 цаг 48 минут буюу индексийн үзүүлэлт 0,742 “В” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.	100%
	Иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг үр	Мэргэжилтнүүдийн өргөдөл гомдол шийдвэрлэлтийн	

	дүнтэй, чанартай шийдвэрлүүлэх талаар санаачилга гаргаж ажиллана.	байдалд хяналт тавьж өдөр тутам арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. ТЗУХ-ийн мэргэжилтэн Б.Сэрчин явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил тул мэдэгдэх хуудас хүргүүлж сануулсан.	100%
--	---	---	------

4. Шинээр санаачлан хэрэгжүүлсэн ажил

№	Төлөвлөсөн ажил	Хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
1	“Цахим Баянгол дэд хөтөлбөр”-ийн хүрээнд Засаг дарга болон дүүргийн удирдлагууд иргэдтэй уулзаж байгаа уулзалтад иргэний картыг хөтлөн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллана.	1800-1222 тусгай дугаараар иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авч цахим програмд бүртгэн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллаж байна.	100%

5. Бусад ажил

№	Хийх ажил	Хугацаа	Шалгуур үзүүлэлт буюу үр дүн	Тайлбар
1				

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Х.МӨНХЗУЛ

БОЛОВСРУУЛСАН:
ӨРӨГДӨЛ ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Д.ГЭРЭЛЭЭ